



**“ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
 АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх байдал | Хугацаа | Хариуцах нэгж, албан тушаалтан | Тайлбар |
|---|--|---|-------------------------------------|---|---------|
| ЗОРИЛТ 1. ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ | | | | | |
| 1.1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг компанийн хэмжээнд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах; | 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах; /мэдээллийн самбар, цахим хуудас, хэвлэмэл материал г.м/ 2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх, танилцах боломжоор хангах; | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | Захиргаа, хуулийн алба /Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн, Олон нийт, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн/ | |
| 1.2 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, АТГ-аас зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхитэй оролцох, хууль тогтоомжийн дагуу гаргасан шийдвэрийг дагаж мөрдөх; | 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн танилцуулга хийх; 2. АТГ-аас зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхитэй оролцох; 3. АТГ-аас зохион байгуулж буй арга хэмжээнд холбогдох хууль тогтоомж болон тухайн зохион байгуулалтын арга хэмжээнээс хамаарч компанийн ЭБАТ-ыг, шаардлагатай тохиолдолд компанийн нийт ажилтнуудыг оролцуулах; | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | Захиргаа, хуулийн алба /Албаны дарга, ЭБАТ/ | |
| 1.3 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг дэмжих; | 1. ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх; 2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх; | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | Захиргаа, хуулийн алба /Албаны дарга, ЭБАТ/ | |

| | | | | | |
|---|---|---|-------------------------------------|---|--|
| 1.4 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг нийт ажилтнуудад болон шинэ ажилтанд танилцуулсан байх; | 1. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж; 2. Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр; 3. Компанийн дүрэм, дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, заавар; | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | Захиргаа, хуулийн алба /Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн/ | |
| 1.5 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх; | 1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах; 2. АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг зохион байгуулах; | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | Захиргаа, хуулийн алба /Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн/ | |
| ЗОРИЛТ 2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ САНАЛ, САНААЧИЛГА | | | | | |
| 2.1 | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, тайлагнах. | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтийн байдал | 2019 оны 2 сар | Захиргаа, хуулийн алба /Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн, Олон нийт, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн/ | |
| | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | | |
| | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналт | 2019 оны 11 сар | | |
| | | Хүрсэн үр дүн | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | | |
| ЗОРИЛТ 3. ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ | | | | | |
| 3.1 | Компанийн болон толгой компанийн үйл ажиллагааны талаарх өөрийн компанид холбогдох мэдээллийг тухай бүр цахимаар болон дотоодын хурлаар мэдээлэх; | Толгой компанийн болон компанийн үйл ажиллагаа, удирдлагын шийдвэрийн талаар ил тод байдлыг хангаж, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллээр нийт ажилтнуудыг бүрэн хангаж ажиллах; | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | Захиргаа, хуулийн алба /Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн, Олон нийт, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн/ | |
| 3.2 | Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг үр дүнтэй, бодитой хэрэгжүүлэх, цахим | Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг цахим хуудсаар хангах; | 2019 оны 2 сар - 2019 оны 11 сар | Захиргаа, хуулийн алба | |

| | | | | |
|--|--|--|---|--|
| <p>хуудас дахь мэдээллийг шинэчлэн баяжуулж, компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхээр заасан хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулах;</p> | <p>Эрх бүхий байгууллага болон удирдлагын шийдвэр, компанийн төсөв санхүүгийн үйл ажиллагааны холбогдох мэдээллийг ажилтнууддаа болон цахим хуудсаар танилцуулах нөхцлийг бүрдүүлэх;</p> | | <p>/Хууль эрх зүйн мэргэжилтэн, Олон нийт, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн/</p> | |
|--|--|--|---|--|

---- оОо ----